



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 01

Арвайхээр

Г Ажлын хэсэг байгуулах тухай Т

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 5.1, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын бэлтгэлийг хангуулах, бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Бадамгэрэл –аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нээцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гишүүд: Н.Чимэддорж-Ойдов –аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн
Б.Баярмаа - аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтад орохоор бүртгүүлэх иргэний холбогдох материалыг хүлээн авч, баримт бичгийн бүрдлийг комиссын хуралдаанаар хэлэлцэн нягтлан шалгах, шалгалт авах байрны бэлтгэл, шалгалт зохион байгуулах хэвийн нөхцөл байдлыг ханган ажиллахыг ажлын хэсэг (Э.Бадамгэрэл)-т үүрэг болгосугай.



013100003

D:My Doc.togtool TAZ